



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 449

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 96 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн өмчөөс шилжүүлсэн 31,745,500.00 (гучин нэгэн сая долоон зуун дөчин таван мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга хурандаа Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн захирагч хурандаа А.Болдбаатар, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга У.Баярбилэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Дорноговь аймгийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 09
дүгээр сарын 22-ны өдрийн 449
тоот тогтоолын хавсралт

**Дорноговь аймгийн өмчөөс Төрийн өмчид хүлээн авч Зэвсэгт хүчний 336
дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашигла л тад орсон он	тоо шир хэг	Нийт балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Штабын байр	1971	1	31,726,200.00	23,162,643.00	8,563,557.00
2	Чулуун хашаа	1984	1	19,300.00	19,300.00	0.00
				31,745,500.00 (гучин нэгэн сая долоон зуун дөчин таван мянга таван зуун)	23,181,943.00 (хорин гурван сая нэг зуун наян нэгэн мянга есөн зуун дөчин гурван)	8,563,557.00 (найман сая таван зуун жаран гурван мянга таван зуун тавин долоон)